

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

| | | | |
|---|------------------|---------------------|---------------|
| Ярилцлага өгөгчийн нэр | Цэвэгээ | Дугаар | L192 |
| Оршин суугаа аймаг | Ховд | Оршин суугаа сум | Булган сум |
| Төрсөн газар | Булган сум | Төрсөн он | |
| Ажил мэргэжил | Өндөр настан | | |
| Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд | Вангийн хүрээ | Сүм хийдийн дугаар | ХОБГ 095 |
| Одоогийн сүм хийд | | Сүм хийдийн дугаар | |
| Ярилцлага авсан он сар өдөр | 2007 оны 6-р сар | Ярилцлага авсан хүн | С.Билэг-Өрнөх |

Ховд аймгийн Булган Вангийн хүрээ

Цэвэгээ: Энд таван жил, зургаан жил болоод нүүсэн.Бага байхад Дамба багш гэж байсан. Дамба багшийн ахын аавын дүү...

Билэг-Өрнөх: Та хэдэн нас хүртлээ шавилж суусан?

Цэвэгээ: Долоон наснаасаа хүрээ тартал суусан. Хүрээ тараад тэгээд багшийндаа гэрээр сууж байсан. Арван найм, ес хүрчихсэн байх аа.

Билэг-Өрнөх: Та ямар хүрээнд шавилж сууж байсан юм?

Цэвэгээ: Вангийн хүрээнд.

Билэг-Өрнөх: Танай хүрээ хаана байрлаж байсан юм, анх?

Цэвэгээ: Баруунд байсан юм.

Билэг-Өрнөх: Баруун гэдэг чинь ямар газар вэ?

Цэвэгээ: Хятадын газар.

Билэг-Өрнөх: За тэгээд хэдэн онд Монголд нүүж орж ирсэн юм бэ?

Цэвэгээ: Аан?

Билэг-Өрнөх: Хэдэн онд Монголд нүүж орж ирсэн юм бэ?

Билэг-Өрнөх: Ирээд хаана ямар газар байршив?

Цэвэгээ: Ирээд тэр Намбарлин гэдэг чинь тэр адгийн тэнд.

Билэг-Өрнөх: Танайх хэдэн гэрээр нүүдэллэдэг хэдэн ламтай хүрээ байсан юм?

Цэвэгээ: Ээ 100 гаруй ламтай байсан.Бичиг заагаад өөр хүмүүс бас зааж байсан юм. Сампил гэдэг...

Билэг-Өрнөх: Танай хүрээнд ямар бурхан шүтдэг байсан юм?

Цэвэгээ: Зонхов, зонхов.Ганданд байна.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Билэг-Өрнөх: Майдар эргэдэг байсан уу?

Цэвэгээ: Эргэдэг. Майдар бас Ганданд байна.

Билэг-Өрнөх: Хэдийд яаж эргэх вэ, та наг сайн яриад өг дөө, майдрыг?

Цэвэгээ: Майдар 16-нд эргэдэг юм. Цагаан сар болсон ард 15, 16-нд эргэдэг юм.

Билэг-Өрнөх: Тэгэхээр юу хийх вэ, ямар зан үйл хийх вэ?

Цэвэгээ: Аа тэр чинь их явдалтай. Шинэ газар дөрвөн зүгээр өмнө зүг, хойд зүг баруун зүг, зүүн зүг гэсэн дөрвөн зүгт дөрвөн нүд байдаг юм. Хүрээ эргэж тэндээ хурна аа. Тэрийг бага сага банди нар зонхов засчихаад, майдар засчихаад бүрээ бишгүүр.Тэгээд бичиг ном заана аа. Тангад ном заана. Вангийн хүрээ л байсан.

Билэг-Өрнөх: Ойр хавьд нь хүрээ байгаагүй юу, тийм ээ?

Цэвэгээ: Ойр хавьд нь хүрээ байгаагүй.Яст мэлхий тавина аа. Шагай цохино. Харцага цохичихно.

Билэг-Өрнөх: Яст мэлхий тавина гэж юу гэсэн үг вэ?

Цэвэгээ: Яст мэлхий тавина гэдэг чинь одоо яст мэлхий тавина. Шагайг л яст мэлхий дүрстэй тахвьж байгаад л.

Билэг-Өрнөх: Хэдийд тавьдаг юм?

Цэвэгээ: Майдрын 16-нд тавьдаг юм. Майдрын 16-нд тавьдаг юм аа.

Билэг-Өрнөх: За тэр ямар учиртай, юунд сайн гэнэ?

Цэвэгээ: Булаг усанд сайн. Яст мэлхий өрөөд тавьдаг юм, хөлтэй гартай. Гарыг нь шагайгаар өрөөд будмал шагайгаар. Таван өнгийн шагай, улаан, цагаан, шар, одоо энгийн шагайгаар тавина. Тийм шагайгаар тавина. Булаг усан Дүлцэн гэж юм байдаг юм. Дүлцэнгээ залж, тийм зургаа тавиад тэгээд Дүлцэнгээ залдаг тийм юм тавьдаг байсан юм. Аа тэр хэн гэдэг хүн байсан юм. Амба гэж маарамба гэж хүн байсан юм. Маарамба байсан. Энэ хэний ах нь байсан байна лээ, Очир гэж байсан байна лээ.Бүрэнтөгсийн гэж байсан байна лээ . Ахыг нь Очир гэдэг гэдэг. Бүрэнтөгсийн ахыг нь л...Дамба гэж хүн байсан. Тэр энэ Харгайтад нүүж байгаад замдаа үхсэн.Тэгээд Харгайтын дээд талд тавьсан байна. Одоо ч байх байх аа.

Билэг-Өрнөх: Вангийн хүрээний нэг хэдэн лам нар Улаанбаатар луу явсан гэж байна ш дээ, Гандан хийд рүү?

Цэвэгээ: Тийм.

Билэг-Өрнөх: Тэрний тухай та мэдэх үү, хэдэн онд явсан юм бэ? Хэдэн лам явсан юм бэ?

Цэвэгээ: Өө арваад лам явсан. Адгийн багын Жамба, Жамбуу давхилаа. Араас нь Гэнцог байхгүй. Манай Ренцэн гэлэн бас явсан.

Билэг-Өрнөх: Тэр лам нар ямар учиртай явсан юм?

Цэвэгээ: Өө бурхны шашинд л суралцах гээд, Ганданд...

Билэг-Өрнөх: Хэдэн онд явсан?

Цэвэгээ: Ерэн таван онд явсан.

Билэг-Өрнөх: Гандан луу явчихсан юм байна , тийм ээ?

Цэвэгээ: Гандан луу явчихсан, цугаараа явсан. 11, 12 лам явсан. Лүвсан, Гомбодамир гэдэг хоёр хүн байхгүй одоо, нас барчихсан гэнэ лээ. Манай энэ Гандан чинь хийд манай хүрээнээс дацан авч хүрээ болсон юм. Гандан

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

ийм байгаагүй юм, манай хүрээнээс дацан аваад, лам нар аваад.Тэгээд манай хүрээнээс дацан аваад, одоо хүрээ болдог дацангийн нь аваад тэгээд хүрээ болсон, Гандан. Одоо бүр хийд болсон байна лээ.